

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өлгий сумын Хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2024/61/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл
Өлгий хот	Утас: 70422954 Цахим хаяг:
2024 он	Аудитын менежер: Х.Женисбек
	Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
	“Уужим Алтай Аудит” ХХК-ны захирал: Б.Галымбек
	Утас: 99101563 Цахим хаяг:

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал.....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
4.5.1 Завсрын аудитын талаар.....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	15
5.1 Төлбөрийн акт	15
5.2 Албан шаардлага.....	15
5.3 Зөвлөмж	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

ӨЛГИЙ СУМЫН ХҮҮХДИЙН
5 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ К.АСЕМГҮЛ ТАНАА

2024.02.23 № 327
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлгий сумын хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өлгий сумын хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлантай холбоотой онцлог асуудал байхгүй байна.

Аудитын гол асуудал

Цэцэрлэгийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой анхаарал татах асуудал байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторовын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

00402394

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ

Өлгий сумын хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>29,875,372.21</u>	<u>115,128,656.70</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	257,100.00	103,425,791.70
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	257,100.00	103,425,791.70
3121	Төгрөг	257,100.00	103,425,791.70
31211	Төрийн сангийн харилцах	257,100.00	103,425,791.70
33	АВЛАГА	3,759,797.31	2,941,720.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	3,759,797.31	2,941,720.00
35	БАРАА МАТЕРИАЛ	25,858,474.90	8,761,145.00
354	Хангамжийн материал	25,858,474.90	8,761,145.00
35420	Аж ахуйн материал	2,539,156.00	2,609,156.00
35460	Хүнсний материал	3,982,199.00	5,305,839.00
35470	Бусад хангамжийн материал	19,337,119.90	846,150.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>617,377,993.57</u>	<u>594,899,027.48</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	617,377,993.57	594,899,027.48
392	Биет хөрөнгө	545,107,993.57	521,229,509.13
39201	Барилга, байгууламж, орон сууц	647,427,732.00	647,427,732.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(116,726,284.65)	(143,106,141.69)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	25,880,085.00	31,985,085.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(16,118,040.10)	(19,367,062.94)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	12,465,006.00	12,465,006.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,174,249.68)	(11,528,854.24)
39217	Ном	3,353,745.00	3,353,745.00
393	Биет бус хөрөнгө	72,270,000.00	73,669,518.35
39301	Програм хангамж	550,000.00	1,973,239.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(550,000.00)	(573,720.65)
39303	Бусад биет бус хөрөнгө	72,270,000.00	72,270,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>647,253,365.78</u>	<u>710,027,684.18</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1,228,665.00</u>	<u>2,694,083.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,228,665.00	2,694,083.00
413	Өглөг	1,228,665.00	2,694,083.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		2,262,083.00
4136	Бусад өглөг	1,228,665.00	432,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	1,228,665.00	432,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>646,024,700.78</u>	<u>707,333,601.18</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	646,024,700.78	707,333,601.18
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	296,241,516.00	296,241,516.00
51101	Өмч: - төрийн	296,241,516.00	296,241,516.00
512	Хуримтлагдсан үр дүн	(108,110,605.92)	(46,801,705.52)
51210	Өмнөх үеийн үр дүн	(108,110,605.92)	(108,110,605.92)
51220	Тайлант үеийн үр дүн		61,308,900.40
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	457,893,790.70	457,893,790.70
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>647,253,365.78</u>	<u>710,027,684.18</u>

Өлгий сумын хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	530,131,100.00	874,747,539.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	5,779,239.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	5,779,239.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		5,779,239.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	530,131,100.00	868,968,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	453,183,300.00	771,774,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		771,774,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	453,183,300.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	215,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	215,000.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	76,732,800.00	97,193,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	76,732,800.00	97,193,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	554,723,262.48	813,438,638.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	554,723,262.48	813,438,638.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	547,737,232.48	813,438,638.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	365,210,387.86	515,319,689.61
210101	Үндсэн цалин	335,094,187.86	342,102,870.78
210102	Нэмэгдэл		145,777,108.77
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	25,871,000.00	27,439,710.06
210105	Гэрээт ажлын хөлс	4,245,200.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,255,200.00	68,852,566.00
210201	Тэтгэврийн даатгал	34,661,100.00	47,597,466.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,648,500.00	5,314,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,918,800.00	4,250,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	729,700.00	1,062,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,297,100.00	10,627,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	76,432,800.00	96,693,900.00
210301	Гэрэл, цахилгаан	3,827,600.00	10,666,624.00
210302	Түлш, халаалт	65,361,760.00	77,966,276.00
210303	Цэвэр, бохир ус	7,243,440.00	8,061,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,086,000.00	18,490,969.90
210401	Бичиг хэрэг	390,600.00	
210402	Тээвэр, шатахуун	146,000.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	333,800.00	
210404	Ном, хэвлэл	48,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,039,600.00	18,490,969.90
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	128,000.00	
2105	Нормативт зардал	24,449,309.00	66,667,808.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	71,544.00	
210502	Хоол, хүнс	23,901,665.00	66,667,808.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	476,100.00	

Өлгий сумын хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	300,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	300,000.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	477,400.00	1,292,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	84,100.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		1,292,500.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	143,300.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,526,135.62	45,621,205.09
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		12,109,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	404,500.00	3,504,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	29,121,635.62	30,007,205.09
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,986,030.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,986,030.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,986,030.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(24,592,162.48)	61,308,900.40
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(24,592,162.48)	61,308,900.40

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	530,131,100.00	868,968,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	530,131,100.00	868,968,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	453,183,300.00	771,774,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		771,774,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	453,183,300.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	215,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	215,000.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	76,732,800.00	97,193,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	76,732,800.00	97,193,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	525,041,100.00	764,050,608.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	525,041,100.00	764,050,608.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	518,055,070.00	764,050,608.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	364,853,400.00	512,239,529.30
210101	Үндсэн цалин	334,737,200.00	339,022,710.47
210102	Нэмэгдэл		145,777,108.77
210104	Урамшуулал	25,871,000.00	27,439,710.06
210105	Гэрээт ажлын хөлс	4,245,200.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,255,200.00	68,852,566.00

Өлгий сумын хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

210201	Тэтгэврийн даатгал	34,661,100.00	47,597,466.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,648,500.00	5,314,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,918,800.00	4,250,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	729,700.00	1,062,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,297,100.00	10,627,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	76,432,800.00	96,693,900.00
210301	Гэрэл, цахилгаан	3,827,600.00	8,327,600.00
210302	Түлш, халаалт	65,361,760.00	80,305,300.00
210303	Цэвэр, бохир ус	7,243,440.00	8,061,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,824,000.00	-
210401	Бичиг хэрэг	390,600.00	
210402	Тээвэр, шатахуун	79,300.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	265,100.00	
210404	Ном, хэвлэл	48,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,041,000.00	
2105	Нормативт зардал	24,171,070.00	69,220,113.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	73,900.00	
210502	Хоол, хүнс	23,621,070.00	69,220,113.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	476,100.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	300,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	300,000.00	500,000.00
2107	Томилолт, зочны зардал	80,000.00	-
210702	Дотоод албан томилолт	80,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	373,800.00	1,182,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	123,800.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		1,182,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	764,800.00	15,362,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		11,802,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	764,800.00	3,559,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,986,030.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,986,030.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,986,030.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>5,090,000.00</u>	<u>104,917,691.70</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	5,090,000.00	1,749,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,090,000.00	1,749,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,090,000.00	1,749,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,090,000.00	1,749,000.00

Өлгий сумын хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(5,090,000.00)	(1,749,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	103,168,691.70
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		257,100.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		103,425,791.70

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	296,241,516.00	457,893,790.70	-108,110,605.92	646,024,700.78
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	296,241,516.00	457,893,790.70	-108,110,605.92	646,024,700.78
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	296,241,516.00	457,893,790.70	-108,110,605.92	646,024,700.78
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	296,241,516.00	457,893,790.70	-108,110,605.92	646,024,700.78
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	296,241,516.00	457,893,790.70	-108,110,605.92	646,024,700.78
D08	Тайлант үеийн үр дүн			61,308,900.40	61,308,900.40
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	296,241,516.00	457,893,790.70	-46,801,705.52	707,333,601.18

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		257,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	868,968,300.00	765,799,608.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	868,968,300.00	765,799,608.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	868,968,300.00	765,799,608.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	606,035,000.00	512,239,529.30
210101	Үндсэн цалин	389,868,900.00	339,022,710.47
210102	Нэмэгдэл	190,617,300.00	145,777,108.77
210104	Урамшуулал	25,548,800.00	27,439,710.06
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,046,400.00	68,852,566.00
210201	Тэтгэврийн даатгал	51,711,300.00	47,597,466.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,084,000.00	5,314,000.00

Өлгий сумын хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

210203	ҮОМШӨ-ний даатгал	4,866,900.00	4,250,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,216,900.00	1,062,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,167,300.00	10,627,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	96,693,900.00	96,693,900.00
210301	Гэрэл, цахилгаан	8,327,600.00	8,327,600.00
210302	Түлш, халаалт	80,305,300.00	80,305,300.00
210303	Цэвэр, бохир ус	8,061,000.00	8,061,000.00
2105	Нормативт зардал	71,335,200.00	69,220,113.00
210502	Хоол, хүнс	71,335,200.00	69,220,113.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,182,500.00	1,182,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,182,500.00	1,182,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,175,300.00	17,111,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,627,900.00	13,551,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,547,400.00	3,559,400.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	868,968,300.00	868,968,300.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	771,774,400.00	771,774,400.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	771,774,400.00	771,774,400.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	97,193,900.00	97,193,900.00
132001	Орон нутгийн төсвөөс	97,193,900.00	97,193,900.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		257,100.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		103,425,791.70
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	34	34
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	17	17
620003	Үйлчлэх ажилтан	16	16
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	175	175
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	175	175
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	175	175
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	34	34
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	18	18
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	16	16

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт төсөв аваагүй байна.

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Өлгий сумын хүүхдийн 5 дугаар цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагаа явуулдаг, Боловсрол шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Тайлант онд “Хамтын оролцоо үнэлгээний үр дүнд суурилсан цэцэрлэгийн менежментийг сайжруулж, хамрагдалтыг нэмэгдүүлэн, сургуулийн өмнөх боловсролын чанарт ахиц гаргана” гэсэн зорилго, “Багшийн хөгжлийг дэмжих, ажлын байранд хөгжих нөхцөл бололцоогоор хангах сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх” зорилт дэвшүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Цэцэрлэг нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Улсын Их хурлаас 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдөр Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль хуулийг шинэчлэн баталсан байна.

Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхгүй хэмжээний өөрчлөлт орсон.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккруэл суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт *үр нөлөөтэй* байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлгий сумын хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Өлгий сумын хүүхдийн 5 дугаар цэцэрлэг нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй ба тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Өлгий сумын хүүхдийн 5 дугаар цэцэрлэг нь 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Өлгий сумын хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 62.8 сая төгрөгөөр буюу 9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	257.10	103,425.79	103,168.69
Авлага	3,759.80	2,941.72	-818.08
Урьдчилгаа	0.00	0.00	0.00
Бараа материал	25,858.47	8,761.15	-17,097.33
Үндсэн хөрөнгө	617,377.99	594,899.03	-22,478.97
Нийт хөрөнгө	<u>647,253.37</u>	<u>710,027.68</u>	<u>62,774.32</u>
Өр төлбөр	1228.67	432.00	-796.67
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	646024.70	709595.68	63570.98
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	<u>647,253.37</u>	<u>710,027.68</u>	<u>62,774.32</u>

Мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо дансдад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгийн данс оны эцэст 103.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь цалингийн зардлыг хэмнэлттэй зарцуулсантай холбоотой байна.

Бараа материалын данс 17.1 сая төгрөгөөр буурсан нь он удаан жил болсон хуучирч элэгдсэн 18.4 сая төгрөгийн бусад хангамжийн материалыг акталж данснаас хассантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс 22.5 сая төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 1.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө авсан, үнэ төлбөргүй 5.8 сая төгрөгийн хөрөнгө хүлээн авсан, үндсэн хөрөнгөнд 30.0 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Тайлант онд 63.6 сая төгрөгийн үр дүнтэй ажилласантай холбоотой Засгийн газрын хувь оролцоо данс нэмэгдсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны батлагдсан төсөвт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 771.8 сая, орон нутгийн төсвөөс 97.2 сая, нийт зарлагыг 868.9 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 771.8 сая төгрөгийг улсын төсвөөс, 97.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 771.8 сая, орон нутгийн төсвөөс 97.2 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 574.6 сая төгрөг буюу 83.7 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 111.7 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Өлгий сумын хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	/мянган төгрөгөөр/		
			Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөр				
1	Эрүүл мэндийн дэмжих	1,773.70	1,773.70	0.00	100.00%
2	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	71,335.20	69,220.11	-2,115.09	97.04%
3	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	3,695.20	3,695.20	0.00	100.00%
4	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	1,773.70	1,709.40	-64.30	96.37%
5	Боловсролын стандарт, сургалт	457,902.00	365,611.62	-92,290.38	79.84%
6	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	235,294.60	226,595.67	-8,698.93	96.30%
7	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	97,193.90	97,193.90	0.00	100.00%
	Дүн	868,968.30	765,799.61	-103,168.69	88.13%

Эх сурвалж: Аудитын судалгаа

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Нэмэлт төсөв аваагүй байна.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Өлгий сумын 5 дугаар цэцэрлэг 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Өлгий сумын 5 дугаар цэцэрлэг нь 2023 онд батлагдсан төсвийн хүрээнд 81.6 сая төгрөгийн бараа материал худалдан авсан байна

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Өлгий сумын 5 дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах үндсэн үйл ажиллагаа болон шилэн дансны хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Уужим Алтай аудит” ХХК-ны захирал бөгөөд аудитор Б.Галымбек гүйцэтгэж, хяналтыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Өлгий сумын 5 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Уужим Алтай Аудит” ХХК-нд 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Өлгий сумын хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Өлгий сумын 5 дугаар цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 624.1 сая төгрөгийн 2 хувиар буюу 12.5 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох *шаардлагагүй* гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 31 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлсэн. Алдаа, зөрчил илрээгүй.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 31 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлсэн.

Алдаа, зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 152.8 сая төгрөгийн 17 орлогын мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 76.7 сая төгрөгийн 5 зарлагын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 22.6 сая төгрөгийн 4 шийдвэр, өр, авлага үүсгэсэн 5.6 сая төгрөгийн 3 шийдвэрийг шилэн дансанд мэдээлээгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 32.5 хувьтай байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчил илрээгүй.

Өлгий сумын хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Өлгий сумын 5 дугаар цэцэрлэгийн 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 89.5 сая төгрөгийн 6 гүйлгээг шилэн дансанд байршуулаагүй, шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилт 84.4 хувьтай зөрчилд зөвлөмж өгөгдсөнийг давтан шалгахад зөрчлийг давтан гаргасан байна. Тайлант оны аудитаар албан шаардлага өгөв.

Хүснэгт 4 Зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	0		0		
Албан шаардлага	0		0		
Зөвлөмж	1	89,497.9			
Нийт дүн	1	89,497.9			

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд 2.3 сая төгрөгийн алдаа¹ илэрч, залруулга хийв. Үүнд: ХХОАТ-ын өр төлбөрийг санхүүгийн тайланд тусгаагүй байсныг залруулав.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын санхүүгийн тайлан гаргах заавар аргачлал, УСНББОУС 1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 276.6 сая төгрөгийн зөрчил² илэрч албан шаардлага өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

5.2 Албан шаардлага

Аудитаар 276.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөв. Үүнд:

1. Цэцэрлэгийн эрхлэгчийн 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн Б/32 дугаар тушаалаар бусад хангамжийн бараа материалын данснаас 18.5 мянган төгрөгийн материалыг Өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлт гаргуулаагүй, холбогдох зөвшөөрөлгүйгээр акталж данс бүртгэлээс хассан, устгалтын акт үйлдэж баримтжуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг “Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хөрөнгийг худалдах, шилжүүлэх, устгахад дараах журмыг баримтална”, 1/

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Өлгий сумын хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

“худалдах, шилжүүлэх, устгах эд хөрөнгийн талаар өмч хамгаалах Байнгын зөвлөл дүгнэлт гаргасан байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4-д “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

2. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 152.8 сая төгрөгийн 17 орлогын мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 76.7 сая төгрөгийн 5 зарлагын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 22.6 сая төгрөгийн 4 шийдвэр, өр, авлага үүсгэсэн 5.6 сая төгрөгийн 3 шийдвэрийг шилэн дансанд мэдээлээгүй. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 32.5 хувь 0% байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална.....”, 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ....”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8-д “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”, 7 дугаар зүйлийн 7.1-д “Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ” гэсэн заалт, Засгийн газрын 2019 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын холбогдох заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

5.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ХХОАТ-ын өр төлбөрийг санхүүгийн тайланд тусгаагүй	1	2,262.1			1	2,262.1	1	2,262.1				
Дүн	1	2,262.1			1	2,262.1	1	2,262.1				
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Өлгий сумын хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Холбогдох зөвшөөрөлгүйгээр акталж данс бүртгэлээс хассан, устгалтын акт үйлдэж баримтжуул аагүй.	1	18,490.5			1	18,490.5						
Дүн	1	18,490.5			1	18,490.5						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Шилэн дансны мэдээллийг дутуу дмэээлсэн	1	233,432.8			1	233,432.8						
Дүн	1	233,432.8			1	233,432.8						
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
Дүн												
Нийт дүн	1	233,432.8			1	233,432.8						